ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.04.19 № 205

танай ____________-ны №____________-т

ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.ЭНХБОЛД ТАНАА

"Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 76.9 ХУВЬТАЙ БАЙНА.**

**АУДИТЫН НЭР: УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

**АУДИТЫН КОД: АРА-2024/18-01-ШТА-ГА**

Архангай аймаг 2024 он

**Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа**
Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
**Аудитын менежер Д.Нэргүйбаатар**
Утас: 77332860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
**Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ**
Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn
**Аудитор Б.Азантунгалаг**
Утас: 94658633 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг **www.audit.mn** цахим хаягаар авна уу.

**Тайлан бэлтгэсэн:**
Архангай аймаг дахь
Төрийн аудитын газар


- Товчилсон үгийн тайлбар ............................................. 3-4
- Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй ................. 5-7
- Үндсэн мэдээлэл ........................................................... 7
- Аудитын тайлан ......................................................... 8-18



**Тэргүүлэх аудитор**
**Т.Байгалмаа**

**Аудитын менежер**
**Д.Нэргүйбаатар**

**Ахлах аудитор**
**Г.Цог-Эрдэнэ**

**Аудитор**
**Б.Азантунгалаг**


2024 оны 04 дүгээр сар
Уг тайланг **www.audit.mn** сайтаас үзнэ үү.


Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033-3141 дугаарын факсаар харилцана уу

Хаяг:
Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр
3-р давхар 314 тоот


**БҮЛЭГ А. НИЙТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 97.2% НЬ БАРИМТ БИЧГИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ БОЛОВСРУУЛЖ, САНХҮҮЖҮҮЛСЭН БАЙНА.**

А.1. Шинээр хэрэгжүүлсэн ТАХ-ний зураг төсөл, техникийн баримт бичгийг хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлсэн байна.
А.2. Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 34, шинээр хэрэгжүүлэх 2 нийт 36 төсөл, арга хэмжээг бүрэн тусгасан байна.
А.3. Нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн олгосон санхүүжилт 88.4 хувьтай байна.

**БҮЛЭГ Б. ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 76.2 ХУВИЙГ ХУГАЦААНД НЬ ГҮЙЦЭТГЭЖ ХҮЛЭЭН АВСАН БАЙНА.**

Б. 1. Аймгийн хэмжээнд хэрэгжсэн ТАХ-ний 23.8 хувь буюу 5 ТАХ нь гүйцэтгэгчээс шалтгаалан гэрээний хугацаанд хэрэгжээгүй он дамжжээ.
Б. 2. Төсөл, арга хэмжээнд хууль тогтоомж заавар журмын дагуу захиалагч, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн боловч үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй 3 ТАХ-г улсын комисс хүлээн авсан байна.

Б.3. Тайлант онд ашиглалтад хүлээн авсан 54,850.5 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

**БҮЛЭГ В. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 76.9 ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА.**

В.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээний 82.5 хувийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.
В.2. Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээний 76.9 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.


Дүгнэлт........................................................................................ 19
Зөвлөмж ...................................................................................... 20
Холбогдох байгууллагын санал ............................................... 21
Тайлан баталгаажуулсан тушаал........................................... 22-24
Хавсралт:Судалгаанууд ...............................................................
25-29

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **АДБОУС** | АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ |
| **БОАЖС** | БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД |
| **БШУС** | БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД |
| **БХБС** | БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД |
| **ББАОК** | БАРИЛГА БАЙГУУЛАМЖ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИСС |
| **ГА** | ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ |
| **ГАГ** | ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР |
| **ГХБХБГ** | ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР |
| **ЕБС** | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ |
| **ЗГХЭГ** | ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР |
| **ЗТХС** | ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД |
| **НТШ** | НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ |
| **ОНӨГ** | ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР |
| **СТСХ** | САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС |
| **СХАА** | САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА |
| **ТАХ** | ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ |
| **ТЕЗ** | ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ |
| **УИХ** | УЛСЫН ИХ ХУРАЛ |
| **ҮАГ** | ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР |
| **ХАА** | ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА |
| **ХХААХҮС** | ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД |
| **ХОХБТХ** | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС |
| **ЭМГ** | ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР |
| **ЭМС** | ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД |
| **ЭМТ** | ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ |

## Дүрслэлийн товъёг



| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| 1 | *Хэрэгжсэн ТАХ-ны санхүүжилт, зарцуулалт* | 11 |



## Хүснэгтийн товъёг



| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| 1 | 2023 онд эрх шилжүүлсэн болон өмнөх оноос шилжих төсөл арга хэмжээнд олгосон санхүүжилтийн жагсаалт | 8 |
| 2 | Төсөл, арга хэмжээний төлөвлөлттэй холбоотой санхүүжилтийн жагсаалт | 9 |
| 3 | 2023 онд эрх шилжүүлсэн болон өмнөх оноос шилжих төсөл арга хэмжээнд олгосон санхүүжилтийн жагсаалт/хувиар/ | 10 |
| 4 | *ТАХ-ний санхүүжилтийг ТЕЗ нараар ангилсан жагсаалт* | 10 |
| 5 | Эрх шилжсэн ТАХ-г харьяа Сайд болон ТАХ-ний төрлөөр ангилсан судалгаа | 12 |
| 6 | 2023 онд хэрэгжсэн барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний судалгаа | 13 |
| 7 | Гэрээний хугацаанд хэрэгжээгүй төсөл арга хэмжээний жагсаалт | 13 |
| 8 | Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй ТАХ-ны жагсаалт | 15 |
| 9 | Ашиглалтад хүлээн авсан ТАХ-ний ашиглалтын байдлын судалгаа | 16 |
| 10 | *Аймгийн барилга байгууламжийн нэгдсэн судалгаа* | 17 |
| 11 | Боловсролын салбарын хөрөнгийн ашиглалтын судалгаа | 18 |
| 12 | Соёлын салбарын хөрөнгийн ашиглалтын судалгаа | 18 |
| 13 | *Гэрээгээр он дамжин хэрэгжих ТАХ-ны судалгаа* | 18 |
| 14 | *Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт* | 19 |

**АУДИТЫН НЭР:**

“Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

**АУДИТЫН КОД:** АРА-2024/18-01-ШТА-ГА

**АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийлээ.

**АУДИТЫН ЗОРИЛТ:**

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар Архангай аймагт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх;
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;

**АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:**

Аудитад Архангай аймагт 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ болон СТСХ, ХОХБТХ, аймгийн ГХБХБГ, ОНӨГ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайланг хамруулан төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг хийлээ.

**АУДИТЫН АРГА ЗҮЙ:**

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

**АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:**

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- ✓ Төсвийн тухай хууль,
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- ✓ Барилгын тухай хууль,
- ✓ Авто замын тухай хууль,
- ✓ Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- ✓ Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- ✓ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- ✓ Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- ✓ Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”,
- ✓ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”,
- ✓ Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт,
- ✓ Архангай аймгийн ИТХ-ын тогтоолууд
- ✓ Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
- ✓ Архангай аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- ✓ Архангай аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө,
- ✓ Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжүүд,
- ✓ Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

## АУДИТ ХИЙСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ, аудитор Н.Энхчимэг, Б.Азантунгалаг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024.02.26-2024.04.19-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

## АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАХ МЭДЭЭЛЭЛ:

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ.
Гүйцэтгэлийн аудитын тайланг асуудлын шинжилгээний 4 дэх түвшний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 3 дахь түвшний асуултын хүрээнд ерөнхийдөө ангилагдан бичигдсэн болно.

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтаар Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад өмнөх оноос он дамжин үргэлжлэн хэрэгжиж буй 287,579.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 төсөл, арга хэмжээг 108,850.5 сая төгрөгөөр, шинээр 1,048.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 арга хэмжээг 1,048.6 санхүүжүүлэхээр баталсан байна. *Эх сурвалж: 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр өөрчлөн найруулж баталсан Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт*

Тайлант жилд 7 сайдын багцаас эрх шилжүүлсэн шинээр болон өмнөх оноос шилжих нийт 36 төсөл, арга хэмжээнд зориулж **70,637.4** сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн ба ажлын гүйцэтгэлд үндэслэн **66,514.1** сая төгрөгийг зарцуулжээ. Хүснэгтээр дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

Хүснэгт 1. /сая.төгрөг/

| № | Харьяа Сайд | Хэрэгжсэн ТАХ-ний тоо | 2023 онд олгосон санхүүжилт | Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт | Барьцаа хөрөнгийн дансанд |
|---|---|---|---|---|---|
| **1** | ЗТХСайд | 6 | 40,687.5 | 40,044.9 | 642.5 |
| **2** | БШУСайд | 19 | 20,910.0 | 18,150.7 | 2,759.3 |
| **3** | ХХААХҮСайд | 2 | 580.8 | 580.8 | - |
| **4** | ЭМСайд | 1 | 274.8 | 274.8 | - |
| **5** | БХБСайд | 2 | 6,667.7 | 5,982.5 | 685.2 |
| **6** | ЭХСайд | 1 | 525.1 | 490.2 | 35.0 |
| **7** | ССайд | 5 | 991.5 | 990.2 | 1.3 |
| **Нийт дүн** | | **36** | **70,637.4** | **66,514.1** | **4,123.3** |

“Төсвийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 10.1.14 дэх заалтыг үндэслэн аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/810 дугаар захирамжаар 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдэл **4,123.2** сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлжээ. */Эх сурвалж: аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 06/265 дугаар албан бичиг/*

<u>Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийн талаар:</u> Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас өмнөх онд “Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн аудитаар нийт **16,971.3** сая төгрөгийн зөрчил илэрч **7,399.3** сая төгрөгийн зөрчилд **11** албан шаардлага, **9,572.0** сая төгрөгийн зөрчилд **6** заалт бүхий зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллагуудад хүргүүлсэн, мөн 2 саналыг ҮАГ-т уламжлан, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан ажилласан. Энэ аудитаар зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг үнэлэв.

# БҮЛЭГ А. НИЙТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 97.2 НЬ БАРИМТ БИЧГИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ БОЛОВСРУУЛЖ, САНХҮҮЖҮҮЛСЭН БАЙНА.

## А.1. ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСӨЛ, ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧГИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛСЭН БАЙНА.

Архангай аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн өмнөх оноос шилжих 34, шинээр хэрэгжих 2 нийт 36 төсөл, арга хэмжээг баталсан байна. Аймгийн Засаг даргад 2023 онд эрх шилжсэн шинээр хэрэгжих 1,498.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн төлөвлөжээ. Төсөл, арга хэмжээний төлөвлөлттэй холбоотой мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. /сая.төг/

| **Хуулийн дугаар** | **Төсөл, арга хэмжээний нэр** | **Төсвийн тухай хуулиар** | | **Ажлын даалгавар батлсан огноо** | **Зураг төсөв, ТЭЗҮ боловсруулсан огноо** | **Магадлалын ерөнхий дүгнэлт** | | **Техникийн нөхцөл олгосон огноо** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төсөвт өртөг | Санхүүжих дүн | | | Огноо | Хянагдсан төсвийн дүн | Цахилгаан хангамж |
| **X.1.3.6.32** | Боловсролын салбарын тоног төхөөрөмж | 500.00 | 500.00 | 2023.02.15 | шаардлагагүй | | | |
| **XIV.1.41** | Сумын төвөөс Бор бургастын рашаан хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын ажил, зураг төсөв /Архангай, Төвшрүүлэх сум/ | 998.6 | 548.6 | 2021.11.24 | 2021.11.24 | 2021.12.21 | 998.6 | 2021.11.11 |
| | **Нийт дүн** | 1,498.60 | 1,048.60 | | | | | |



Харин өмнөх оноос шилжиж ирсэн төсөл арга хэмжээнүүдээс 2022 онд БШУС-аас аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн X.1.1.251 хуулийн дугаартай Архангай аймгийн Ихтамир сумын "Цэцэрлэгийн барилгын өргөтгөл"-ийн барилгыг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан хэдий ч 2024 оны 04 дүгээр сарын байдлаар барилгыг ашиглаж эхлээгүй байна. Энэ нь уг барилгын гадна бохирын болон цэвэр усан хангамжийн систем суурилуулалт, халаалтын шугамын ажлын зураг төсвийг ТЭЗҮ-д бүрэн тусгаагүй, орхигдуулсантай холбоотой байна.



Аудитаар барилгын ТЭЗҮ, зураг төсөвт тусгагдаагүй дутуу ажилд нэмэлт зураг төсөв хийлгэж, ажлыг гүйцэтгүүлэх шат дараатай арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

## А.2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТӨГ, САНХҮҮЖИХ ДҮНГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТООЦОЖ, ӨМНӨХ ОНООС ҮРГЭЛЖЛЭН ХЭРЭГЖИХ 34, ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ 2 НИЙТ 36 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ТУСГАСАН БАЙНА.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар 7-н Сайдын багцаас аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн өмнөх оны 212,044.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 74,183.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 34 ТАХ, шинээр хэрэгжих 1,498.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг тайлант онд бүрэн хэрэгжиж дуусахаар тооцож баталсан байна.

Хүснэгт 3. /сая.төг/

| № | Харьяа Сайд | Хэрэгжих ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | 2023 онд олгох санхүүжилт | Санхүүжилтийн эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | ЗТХСайд | 6 | 125,264.9 | 44,166.4 | 58.7 |
| **2** | БШУСайд | 18 | 43,505.4 | 20,496.5 | 27.2 |
| **3** | ХХААХҮСайд | 2 | 751.0 | 591.0 | 0.8 |
| **4** | ЭМСайд | 1 | 350.0 | 280.0 | 0.4 |
| **5** | БХБСайд | 2 | 31,987.1 | 6,667.7 | 8.9 |
| **6** | ЭХСайд | 1 | 998.6 | 548.6 | 0.7 |
| **7** | ССайд | 6 | 10,685.9 | 2,481.8 | 3.3 |
| **Нийт дүн** | | **36** | **213,542.9** | **75,232.0** | **100.0** |

Нийт 36 төсөл, арга хэмжээний 75,232.0 сая төгрөгийн санхүүжилтийн 58.7 хувь нь ЗТХС-ын, 27.2 хувь нь БШУС-ын, 8.9 хувь нь БХБС-ын, 3.3 хувь нь СС-ын, 0.8 хувь нь ХХААХҮС-ын, 0.7 хувь нь ЭХС-ын, хамгийн бага буюу 0.4 хувь нь ЭМС-ын төслүүд байгаа бөгөөд эдгээр нь магадлалаар баталгаажсан төсвийн дүнд үндэслэн төсөвт өртөг, хэрэгжих хугацаатай уялдуулан санхүүжих дүнг төлөвлөж бүрэн тусгасан байна.

**А.3. НИЙТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ 88.4 ХУВЬТАЙ БАЙНА.**

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн өмнөх оноос шилжих буюу шинээр хэрэгжих 36 ТАХ-ний 2023 оны санхүүжилт 75,232.0 сая төгрөг хийгдэхээс аймгийн Төрийн сангийн дансаар ТАХ-ны гүйцэтгэлд үндэслэн 66,514.1 сая төгрөгийг гүйцэтгэгчид, 4123.2 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. Гүйцэтгэлд олгосон санхүүжилт **88.4** хувьтай байна.

ТАХ-ний санхүүжилтийг ТЕЗ нараар ангилсан судалгаа

Хүснэгт 4. /сая.төг/

| ТЕЗ | Эрх шилжүүлсэн | | Санхүүжилт хийгдсэн | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|---|
| | ТАХ-ний тоо | Санхүүжих дүн | ТАХ-ний тоо | Санхүүжилтийн дүн | ТАХ-ний тоо | Санхүүжилтийн дүн |
| **СС** | 6 | 2,481.8 | 6 | 990.2 | - | 1491.584 |
| **БШУС** | 18 | 20,496.5 | 18 | 18150.7 | - | 2345.8 |
| **БХБС** | 2 | 6,667.7 | 2 | 5982.5 | - | 685.163 |
| **ЭМС** | 1 | 280.0 | 1 | 274.8 | - | 5.2 |
| **ЗТХС** | 6 | 44,166.4 | 6 | 40044.9 | - | 4121.5 |
| **ХХААХҮС** | 2 | 591.0 | 2 | 580.8 | - | 10.192 |
| **ЭХС** | 1 | 548.6 | 1 | 490.2 | - | 58.41 |
| | **36** | **75,232.0** | **36** | **66,514.1** | **-** | **8,717.8** |

Санхүүжилтийн зарцуулалтын байдал

График 1.




Нийт **70,637.3** сая төгрөгийн санхүүжилтийн 93.5 хувь буюу 66,056.9 сая төгрөгийг гүйцэтгэгчид, 0.6 хувь буюу 457.2 сая төгрөгийг зураг төсөв, зохиогчийн хяналтын зардалд, 5.8 хувь буюу 4,123.2 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. */Хэрэгжсэн ТАХ-ний жагсаалтыг тайлангийн хавсралт №1-тэй дэлгэрэнгүй танилцана уу/*



Тайлант онд Сангийн Сайдын 2022.12.16-ны өдрийн 01/8591 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2023.01.16-ны өдрийн А/07 дугаар захирамжийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2023 онд хэрэгжсэн барилга байгууламжийн барилгын материалын үнийн

өсөлтөөс шалтгаалсан төсөвт өртөг нь магадлалын ерөнхий дүгнэлтээр өөрчлөгдсөн 17 төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталж, нэмэлт гэрээ байгуулан 6,057.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгожээ. Дээрх төсөл, арга хэмжээний 41.2 хувь нь 2021-2023 онд ашиглалтад хүлээн авсан 8 барилга байгууламж байна.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 2022 оноос хэрэгжсэн Соёлын Сайдын багцаас /XI.1.54/ хуулийн дугаартай "Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын ажил"-ын гүйцэтгэгч "Энигма констракшн" ХХК-тай 2022.05.01-ээс 2023.11.20-ыг хүртэл хугацаанд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ч гэрээний хугацаанд ажил хийгдээгүй мөн 2022 онд батлагдсан нийт санхүүжилтээс 2022.06.30-нд урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 525.0 сая төгрөгийг илүү олгосон байна. Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/314 дугаар захирамжийн дагуу газрын байршил өөрчлөгдсөнтэй холбоотой 2024.04.01-ны өдрийн байдлаар буюу 21 сарын хугацаанд ажил хийгдээгүй гэрээний үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Аудитаас урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаснаас хойш 21 сарын хугацаанд ажлын гүйцэтгэл гараагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж хариуцлага тооцох арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

# БҮЛЭГ Б. ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 76.2 ХУВИЙГ ХУГАЦААНД НЬ ГҮЙЦЭТГЭЖ ХҮЛЭЭН АВСАН БАЙНА.

## Б. 1. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖСЭН ТАХ-НИЙ 23.8 ХУВЬ БУЮУ 5 ТАХ НЬ ГҮЙЦЭТГЭГЧЭЭС ШАЛТГААЛАН ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД ХЭРЭГЖЭЭГҮЙ ОН ДАМЖЖЭЭ.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу аймгийн Засаг даргад 2023 онд 7 Сайдын багцаас өмнөх оноос шилжсэн болон шинээр хэрэгжихээр эрх шилжүүлсэн 213,542.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 210,976.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 36 ТАХ-ний гэрээний хэрэгжилтийг авч үзэхэд 22.2 хувь буюу 8 барилга байгууламжийг 2021-2022 онд улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан ба барилгын материалын үнийн зөрүү тооцуулж төсөв баталсан байна.

Тайлант онд 7 Сайдын багцаас эрх шилжин хэрэгжсэн 195,932.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 28 ТАХ-ээс 68,730.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 18 барилга, байгууламж, 121,588.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 5 зам, гүүрний байгууламж, 1,539.2 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 4 тоног төхөөрөмжийн ажлууд байна. Харин Соёлын Сайдаас эрх шилжүүлсэн 4,075.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй XI.1.54 хуулийн дугаартай “Төв Монголын байгаль, түүх соёлын цогцолборын барилга”-ын ажил эхлээгүй байна.

Эрх шилжсэн ТАХ-г харьяа Сайд болон ТАХ-ний төрлөөр ангилж харуулбал

Хүснэгт 5. /сая.төг/

| № | Харьяа Сайд | Нийт ТАХ | | Барилга байгууламж | | Зам, гүүрийн байгууламж | | Тоног төхөөрөмж | | Эхлээгүй ажил | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Гэрээний дүн | ТАХ-ний тоо | Гэрээний дүн | ТАХ-ний тоо | Гэрээний дүн | ТАХ-ний тоо | Гэрээний дүн | ТАХ-ний тоо | Гэрээний дүн | ТАХ-ний тоо |
| *1* | БХБС | 26,964.9 | 1 | 26,964.9 | 1 | | | | | | |
| *2* | БШУС | 37,213.9 | 14 | 36,715.7 | 13 | | | 498.2 | 1 | | |
| *3* | СоС | 8,599.7 | 4 | 4,524.4 | 3 | | | | | 4,075.3 | 1 |
| *4* | ЗТХС | 121,588.0 | 5 | | | 121,588.0 | 5 | | | | |
| *5* | ХХААХҮС | 696.2 | 2 | | | | | 696.2 | 2 | | |
| *6* | ЭХС | 525.1 | 1 | 525.1 | 1 | | | | | | |
| *7* | ЭМС | 344.8 | 1 | | | | | 344.8 | 1 | | |
| ***Нийт дүн*** | | **195,932.6** | **28** | **68,730.1** | **18** | **121,588.0** | **5** | **1,539.2** | **4** | **4,075.3** | **1** |

Барилга байгууламжийн 18, зам, гүүрний байгууламжийн 5 нийт 23 ТАХ-ний хэрэгжилтийг шалгахад аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь зохиогчийн, зөвлөх үйлчилгээний болон захиалагчийн хяналтын тайланг авч ил далд ажлын актыг баримтжуулан фото зургаар баталгаажуулан санхүүжилтийг хянаж олгож байгаа нь урьд жилүүдэд гарч байсан санхүүжилт илүү олгож байсан зөрчлийг бүрэн арилгаж ажилласан байна. */эх сурвалж: Төсөл, арга хэмжээ тус бүрээр санхүүжилтийн гүйцэтгэлийн тулгалт хийсэн горим сорил болон цахим нотлох баримтад үндэслэв/*

Тоног төхөөрөмжийн 4 ТАХ-г шалгахад захиалагч батлагдсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэгчээс комиссын актаар хүлээн авч, гэрээг дүгнэж ажилласан байна.

Аудитаар барилга байгууламжаас түүвэрлэн газар дээр нь очиж 6 ТАХ-г зураг, төсвийн дагуу хэрэгжүүлснийг шалгахад БШУС-аас эрх шилжсэн "Багшийн хөгжил, судалгааны арга зүйн төвийн барилга" нь ашиглалтын явцад 1, 3 давхрын 2 өрөөний дүүргэлтийн хана хагарч цуурал үүссэн, дээвэр лүү гарах хаалга гажиж, цоож эвдэрсэн байдалтай байлаа.

Аудитаас гүйцэтгэгч байгууллагаар барилгын ашиглалтын явцад үүссэн эвдрэлийг заслуулах арга хэмжээ авч, биелэлтийг тооцож хариу ирүүлэх албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүллээ.

Аймгийн хэмжээнд 2023 онд хэрэгжсэн эрх шилжээгүй 17, эрх шилжсэн 36 нийт 53 ТАХ хэрэгжжээ.

2023 онд хэрэгжсэн барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний судалгаа

Хүснэгт 6.

| № | Нөхцөл байдал | Эрх шилжсэн ТАХ-ний тоо | Эрх шилжээгүй ТАХ-ний тоо | Нийт ТАХ-ний тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Гэрээний хугацаанд хэрэгжиж барилга байгууламж ашиглалтад оруулах улсын комиссын актаар хүлээн авсан | 24 | 8 | 32 |
| 2 | Гэрээний хугацаанд хэрэгжээгүй | 5 | 8 | 13 |
| 3 | Гэрээгээр он дамжин хэрэгжиж байгаа | 7 | 1 | 8 |
| **Нийт** | | 36 | 17 | 53 |

Архангай аймагт 2023 онд хэрэгжиж дуусаад ашиглалтад орох 45 ТАХ-ний 71.7 хувь буюу 32 ТАХ-г гэрээний хугацаанд улсын комиссын актаар байнгын ашиглалтад бүрэн хүлээн авч, 28.3 хувь буюу 13 ТАХ нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй байна. Үүнээс эрх шилжсэн 5 ТАХ-ний гүйцэтгэл дунджаар 79 хувьтай байна.

Гэрээний хугацаанд хэрэгжээгүй төсөл арга хэмжээ

Хүснэгт 7.

| № | Хуулийн код | Төсөл, арга хэмжээний нэр | Гэрээний дуусах огноо | Шалтгаан | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Х.1.1.33 | Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Цахир сум/ | 2023.08.30 | Гүйцэтгэгчээс | 70.0 |
| 2 | Х.1.1.97 | Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Хайрхан сум/ | 2023.08.30 | Гүйцэтгэгчээс | 70.0 |
| 3 | Х.1.1.132 | Сургуулийн барилгын өргөтгөл /Архангай, Өлзийт сум/ | 2023.08.31 | Гүйцэтгэгчээс | 95.0 |
| 4 | Х.1.1.271 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 150 ор /Архангай, Жаргалант сум/ | 2023.08.30 | Гүйцэтгэгчээс | 85.0 |
| 5 | XI.1.21 | Солийн Данзаны нэрэмжит музей, цэцэрлэгт хүрээлэн /Архангай, Хотонт сум/ | 2023.10.01 | Гүйцэтгэгчээс | 75.0 |
| **Дундаж хувь** | | | | | **79.0** |

Аудитаас Захиалагчтай байгуулсан гэрээний хугацаанд барилгын ажлыг дуусгаж ашиглалтад хүлээлгэж өгөөгүй гүйцэтгэгч нэг бүртэй гэрээг дүгнэж хариуцлага тооцох, барилга байгууламжийг чанартай гүйцэтгүүлж ашиглалтад оруулах талаар арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүллээ.

**Б.2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ХУУЛЬ ТОГТООМЖ ЗААВАР ЖУРМЫН ДАГУУ ЗАХИАЛАГЧ, ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОЛОВЧ ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ 3 ТАХ-Г УЛСЫН КОМИСС ХҮЛЭЭН АВСАН БАЙНА.**

Аймгийн хэмжээнд эрх шилжин хэрэгжсэн 195,932.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 28 ТАХ-ээс 68,730.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 18 барилга, байгууламж, 121,588.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 5 зам, гүүрийн байгууламжийн ажлууд хэрэгжжээ.

Аймгийн ГХБХБГ-ын Барилга хот байгуулалтын хэлтсээс 18 барилга байгууламжид тухай бүр захиалагчийн хяналт хийж, захиалагчийн хяналтын явцын дүгнэлт гарган баталгаажуулж ажилласан байна. ЗТХС-аас эрх шилжсэн 5 зам,

гүүрний байгууламжийн ажилд зөвлөхийн гэрээгээр “Мөнхөд ашдын зам ХХК” 1 ТАХ-нд “Зам тээвэр хөгжлийн төв” 2 ТАХ-нд, “Эн би си си ХХК” 2 ТАХ-нд зөвлөх үйлчилгээг гүйцэтгэж, зөвлөх үйлчилгээний тайлан, дүгнэлт, ил далд ажлын акт үйлдэж баталгаажуулан фото зургаар баримтжуулсан байна. Гүйцэтгэгчдээс өгсөн үүрэг даалгаврыг ил далд ажлын акт үйлдэн захиалагч, зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч нараар баталгаажуулан ажлын гүйцэтгэлд хавсаргажээ.

Гэрээний хугацаанд улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан эрх шилжсэн 12, эрх шилжээгүй 4 нийт 16 барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлд захиалагч, зохиогч, улсын комиссын хяналтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг газар дээр нь очиж тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ БОАЖС-ын багцаас эрх шилжээгүй 2023 онд орон нутагт хэрэгжсэн 1,096.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын барилга /Архангай, Өвөрхангай, Булган/"-ын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссоос өгсөн 9 үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй
- ✓ БШУС-аас эрх шилжүүлсэн 1,978.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Багшийн хөгжил, судалгааны арга зүйн төвийн барилга"-ын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссоос өгсөн 2 үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй.
- ✓ БШУС-аас эрх шилжүүлсэн 1,499.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Архангай, Ихтамир сум/" -ын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссоос өгсөн 5 үүрэг даалгаврыг гүйцэтгэгч талууд ажлын 14 хоногт гүйцэтгээгүй байхад уг барилга байгууламжуудыг ашиглалтад оруулах шаардлага хангасан гэж үзэн байнгын ашиглалтад хүлээн авсан нь МУЗГ-ын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 8.1, 8.2.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Аудитаас Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, ажлыг сайжруулах, үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авахгүй байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

Монгол Улсын Сангийн Сайдын баталсан 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн №СХШХ/08 дугаар удирдамжийн дагуу СЯ-ны санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас Архангай аймагт 2021, 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 100 ТАХ-ний санхүүжилт, гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн байна. Хяналт шалгалтаар гэрээний хугацаанд хэрэгжээгүй 10, ашиглалтгүй 1 нийт 11 ТАХ-тэй холбоотой зөрчлийг арилгуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлжээ.

**Б.3. ТАЙЛАНТ ОНД АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВСАН 54,850.5 САЯ ТӨГРӨГИЙН 14 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ БАЙНА.**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжсэн 66,479.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 20 ТАХ-г улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

Тайлант онд ашиглалтад хүлээн авсан нийт ТАХ-ний 97.9 хувь буюу 65,050.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 11 барилга байгууламж, 2.1 хувь буюу 1,428.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 3 мал амьтад, тоног төхөөрөмж эзэлж байна.

Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй ТАХ, Салбараар

Хүснэгт 8. /сая.төг/

| № | Салбар | Төсөл арга хэмжээний тоо | Бүтгэлд тусгаагүй мөнгөн дүн | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Хөдөө аж ахуй | 1 | 110.50 | 0% |
| 2 | Боловсрол | 2 | 5,334.27 | 10% |
| 3 | Зам тээвэр | 4 | 16,860.41 | 31% |
| 4 | Соёл урлаг | 3 | 3,643.80 | 7% |
| 5 | Байгаль орчин | 1 | 1,096.00 | 2% |
| 6 | Эрүүл мэнд | 2 | 27,280.40 | 50% |
| 7 | Эрчим хүч | 1 | 525.14 | 1% |
| **Нийт дүн** | | **14** | **54,850.53** | **100%** |

Хүснэгтээс харахад 7 салбарын хэмжээнд байнгын ашиглалтад хүлээн авсан 54,850.5 сая төгрөгийн 14 ТАХ-г ашиглагч байгууллага нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2[1], ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.1[2], 4.1.4[3], 4.4[4] дэх заалттай нийцэхгүй байна. /Тайлангийн хавсралт №2 –оос дэлгэрэнгүй танилцана уу/

Аудитаас 2023 онд улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн 13, мал амьтад 1 нийт 14 ТАХ-ний 54,850.5 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах арга хэмжээ авах албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүллээ.

[1] "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"

[2] Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэсэн болон хандив, тусламж, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгахад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах шаардлагагүй

[3] Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ

[4] Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана

# БҮЛЭГ B. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 76.9 ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА.

## B.1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТАЙЛАНТ ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН НИЙТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 82.5 ХУВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ БҮРЭН ХҮЧИН ЧАДЛААР АШИГЛАЖ БАЙНА.

Аймгийн хэмжээнд 2023 онд 7 салбарын хүрээнд хэрэгжиж ашиглалтад хүлээн авсан 66,479.5 сая төгрөгийн 20 ТАХ-ний ашиглалт дунджаар 82.5 хувьтай байна.

Ашиглалтад хүлээн авсан ТАХ-ний ашиглалтын байдал

Хүснэгт 9. /сая.төг/

| ДД | Салбар | Ашиглалтад хүлээн авсан: | | Бүрэн хүчин чадлаар ашиглахгүй байгаа | | Бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа | | Ашиглалтын дундаж хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ТАХ-ний тоо | Мөнгөн дүн | ТАХ-ний тоо | Мөнгөн дүн | ТАХ-ний тоо | Мөнгөн дүн | |
| 1 | Боловсрол | 7 | 16,408.56 | 1 | 1,499.90 | 6 | 14,908.66 | 91% |
| 2 | Эрүүл мэнд | 3 | 27,625.20 | | | 3 | 27,625.20 | 100% |
| 3 | Зам тээвэр | 4 | 16,860.41 | | | 4 | 16,860.41 | 100% |
| 4 | Эрчим хүч | 1 | 525.10 | | | 1 | 525.10 | 100% |
| 5 | Хөдөө аж ахуй | 2 | 580.80 | 1 | 150.0 | 1 | 190.00 | 74% |
| 6 | Байгаль орчин | 1 | 1,096.00 | 1 | 1,096.00 | 0 | - | 0% |
| 7 | Соёл урлаг | 2 | 3,383.39 | | | 2 | 3,383.39 | 100% |
| **Нийт дүн** | | **20** | **66,479.46** | **3** | **2,745.9** | **17** | **63,733.6** | **82.5%** |

Эрүүл мэнд, Зам тээвэр, Эрчим хүч, Соёл урлагийн салбараас хэрэгжүүлсэн 10 ТАХ-г зориулалтын дагуу 100% ашиглаж байна.

Харин боловсрол, Хөдөө аж ахуй, байгаль орчны салбарын хүрээнд хэрэгжүүлсэн 3 ТАХ-г бүрэн хүчин чадлаар ашиглаагүй байна. Тухайлбал:

- ✓ БШУС-аас аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн Х.1.1.251 хуулийн дугаартай Архангай аймгийн Ихтамир сумын "Цэцэрлэгийн барилгын өргөтгөл"-ийн барилгыг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан хэдий ч 2024 оны 04 дүгээр сарын байдлаар барилгыг ашиглаж эхлээгүй байна. Энэ нь уг барилгын гадна бохирын болон цэвэр усан хангамжийн систем суурилуулалт, халаалтын шугамын ажлын зураг төсвийг ТЭЗҮ-д бүрэн тусгаагүй, орхигдуулсантай холбоотой байна.
- ✓ БОАЖС-ын багцаас эрх шилжээгүй 2023 онд орон нутагт хэрэгжсэн 1,096.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын барилга /Архангай, Өвөрхангай, Булган/"-ын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан хэдий ч 2024 оны 04 дүгээр сарын байдлаар ашиглаж эхлээгүй байна.
- ✓ . ХХААХҮС-аас эрх шилжсэн, өмнөх оноос шилжих XIII.3.10 хуулийн дугаартай Малын үүлдэг угсаа сайжруулах төслийн хүрээнд, хосолмол ашиг шимтэй Монбелиард үүлдрийн 150,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 19 үхрийг түрээслэх гэрээнд 10 төл тутмаас 1 тугалыг түрээсийн төлбөрт төлөхөөр гэрээ байгуулсан боловч түрээсийн төлбөр төлөх нарийвчилсан хуваарь гаргаагүй ашиглалт хангалтгүй байна.

Аудитаас Төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэх чиглэлийг баримтлан малын түрээсийн төлбөр төлөх

хуваарь, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэх замаар түрээсийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүллээ.

## В.2. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖСЭН НИЙТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 76.9 ХУВЬ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА.

Аймгийн хэмжээнд 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн нийт 36 ТАХ-ээс 8 ТАХ нь өмнөх онд ашиглалтад орсон, 7 нь гэрээгээр он дамжсан, 5 ТАХ нь гэрээний хугацаанд хэрэгжээгүй байна. Харин тайлангийн жилд хэрэгжүүлсэн 16 ТАХ нь тэргүүлэх ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, 76.9%-ийн төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

### ***1. Боловсролын салбар***

Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжиж ашиглалтад орсон боловсролын салбарын 5 барилга байгууламжийн ашиглалт, хүрсэн үр дүн 80 хувьтай байна.

Хүснэгт 11.

| Салбар | Хуулийн код | Төсөл арга хэмжээний нэр | Хэрэгжсэн ТАХ-ний хүчин чадал | Одоо байгаа суралцагчийн тоо /2 ээлжээр/ | Хувь |
|---|---|---|---|---|---|
| Боловсрол | X.1.1.36 | Сургуулийн өргөтгөлийн барилга, урлаг, спорт заал, 320 суудал /Архангай, Чулуут сум/ | 320 | 373 | 100% |
| | X.1.1.325 | Сургуулийн барилга, спорт заал, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 4 дүгээр сургууль/ | 160 | 160 | 100% |
| | X.1.1.190 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 2 дугаар цэцэрлэг/ | 150 | 175 | 100% |
| | X.1.1.251 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Архангай, Ихтамир сум/ | 50 | 0 | 0% |
| | X.1.1.326 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Батцэнгэл сум, 1 дүгээр баг/ | 150 | 75 | 100% |
| | | | **830** | **1179** | **80%** |

### **2. Соёлын салбар**

Аймгийн хэмжээнд 2023 онд хэрэгжиж ашиглалтад орсон соёлын салбарын 3 барилга байгууламжийн хүчин чадал 740 суудалтай ба 3 сумын хэмжээнд 11306 хүн амд соёлын үйлчилгээг хүргэхээс гүйцэтгэлийн үр дүн сард дунджаар 1.4 дахин илүү гүйцэтгэлтэй буюу 100% төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

Хүснэгт 12.

| Салбар | Хуулийн код | Төсөл, арга хэмжээ | Нийт хүн амын тоо | Суудлын тоо | Хүрсэн түвшин дунджаар /сараар/ |
|---|---|---|---|---|---|
| Соёл урлаг | XII.1.1.54 | Соёлын төвийн барилга, 250 суудал /Архангай, Чулуут сум/ | 4113 | 250 | 362 |
| | XII.1.1.62 | Соёлын төвийн барилга, 250 суудал /Архангай, Булган сум/ | 2814 | 250 | 362 |
| | XII.1.1.74 | Соёлын төвийн барилга, 240 суудал /Архангай, Жаргалант сум/ | 4379 | 240 | 362 |
| **Нийт дүн** | | | **11306** | **740** | **1086** |

Аймгийн Засаг даргад 2023 онд эрх шилжүүлсэн өмнөх оноос шилжих 34 төсөл, арга хэмжээнээс гэрээгээр он дамжин хэрэгжих 7 ТАХ-ний бодит гүйцэтгэлийг аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот түвшинтэй харьцуулан дүн шинжилгээ хийхэд ажлын гүйцэтгэл дунджаар 71.1 хувьтай хэрэгжих зорилтыг дэвшүүлсэн ч аудитаар бодит гүйцэтгэл дунджаар 50.8 хувьтай байна.

Хүснэгт 13.

| № | Хуулийн код | Төсөл, арга хэмжээний нэр | Аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтот түвшин | Аудитаарх 2023 оны бодит ажлын гүйцэтгэл /хувиар/ |
|---|---|---|---|---|
| 1 | IX.1.127 | Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/ | 30% | 25% |
| 2 | X.1.1.78 | Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 50 ор /Архангай, Тариат сум/ | 100% | 92% |
| 3 | X.1.1.278 | Бага сургуулийн барилга, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 6 дугаар баг/ | 100% | 62% |
| 4 | X.1.1.282 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Хотонт сум/ | 100% | 72% |
| 5 | XI.1.54 | Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/ | 70% | 0% |
| 6 | XII.1.1.8 | Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай, Батцэнгэл сум/ | 68% | 71% |
| 7 | XII.1.1.67 | Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 65.8 км /Архангай, Ихтамир, Чулуут сум/ | 30% | 34% |
| **НИЙТ ДҮН** | | | **71.1%** | **50.8%** |

Хүснэгтээс харахад төлөвлөсөн үр дүн дунджаар 50.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

1. ХХААХҮС-аас эрх шилжсэн, өмнөх оноос шилжих XIII.3.10 хуулийн дугаартай "Малын ногоон тэжээл тариалах төсөл"-ийн хүрээнд 1-р багцаар 345,550.0 мянган төгрөгийн Foton lovol үр тарианы комбайн худалдан авч 3 иргэнтэй түрээсийн гэрээ байгуулан 16,000.0 мянган төгрөгөөр түрээслэн, түрээсийн төлбөрөөс 3,309.0 мянган төгрөгийг жолоочийн ажлын хөлсөнд өгч, үлдсэн төлбөр болох 12,691.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх байсан боловч 6,691.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Аудитаас "Түрээсийн гэрээний 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтын дагуу дутуу төвлөрүүлсэн 6,691.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

**Өмнөх аудитаар өгсөн 7 заалт бүхий зөвлөмж, 2 албан шаардлагын хэрэгжилт 88.8 хувьтай байна.**

Өмнөх аудитаар Аймгийн Засаг дарга, ХОХБТХ, ГХБХБГ, ОНӨГ-уудад нийт 7 заалт бүхий зөвлөмж, 2 албан шаардлагыг хүргүүлж, биелэлтийг албан бичгээр тооцож ирүүлсэнг тулган шалгахад аймгийн ОНӨГ-т улсын комиссын актаар хүлээн авсан боловч бүртгэл тайланд тусгаагүй барилга байгууламжийн 5, их засварын 1 нийт 5328.3 сая төгрөгийн 6 ТАХ-ний хөрөнгийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 14

| Холбогдох албан тушаалтан | Хүргүүлсэн зөвлөмж, Албан шаардлагын тоо | Хэрэгжээгүй | Бүрэн хэрэгжүүлсэн |
|---|---|---|---|
| Аймгийн Засаг даргад | 4 | - | 4 |
| Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т | 1 | - | 1 |
| Аймгийн ОНӨГ-т | 2 | 1 | 1 |
| Аймгийн ГХБХБГ-т | 2 | - | 2 |
| **Дундаж хувь** | | | **88.8 %** |

Аймгийн Засаг даргаас өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр 2023 онд төрийн өмчийн барилга байгууламжид судалгаа, хяналт шалгалт үзлэгийг мэргэжлийн байгууллага буюу аймгийн ГХБХБГ-аар гүйцэтгүүлжээ. Нийт 19 сумын 173 барилга байгууламжид үзлэг шалгалт хийж дүгнэлт гарган барилга байгууламжийг үнэлж эрэмбэлсэн байна. Аймгийн хэмжээнд зайлшгүй шинээр барих 32, их засвар хийх 57 нийт 89 барилга байгууламжид нэгдсэн дүгнэлт гаргаж, суурь судалгааны сантай болжээ.

| ДД | Салбар | Тоо |
|---|---|---|
| 1 | Сургууль | 12 |
| 2 | Хүүхдийн цэцэрлэг | 13 |
| 3 | Эрүүл мэндийн төв | 11 |
| 4 | Соёлын төв | 4 |
| 5 | Дотуур байр | 11 |
| 6 | Засаг даргын тамгын газар | 6 |
| | **Их засвар хийх шаардлагатай барилга** | **57** |
| 1 | Сургууль | 2 |
| 2 | Хүүхдийн цэцэрлэг | 11 |
| 3 | Эрүүл мэндийн төв | 6 |
| 4 | Соёлын төв | 2 |
| 5 | Дотуур байр | 3 |
| 6 | Засаг даргын тамгын газар | 8 |
| 7 | Бусад | 0 |
| **Шинээр барих шаардлагатай барилга** | | **32** |
| **Нийт дүн** | | 89 |

# АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ Шинээр хэрэгжүүлсэн ТАХ-ний зураг төсөл, техникийн баримт бичгийг хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлсэн байна.
- ✓ Төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг үндэслэлтэй тооцож, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 34, шинээр хэрэгжүүлэх 2 нийт 36 төсөл, арга хэмжээг бүрэн тусгасан байна.
- ✓ Нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн олгосон санхүүжилт 88.4 хувьтай байна.
- ✓ Аймгийн хэмжээнд хэрэгжсэн ТАХ-ний 23.8 хувь буюу 5 ТАХ нь гүйцэтгэгчээс шалтгаалан гэрээний хугацаанд хэрэгжээгүй он дамжжээ.
- ✓ Төсөл, арга хэмжээнд хууль тогтоомж заавар журмын дагуу захиалагч, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн боловч үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй 3 ТАХ-г улсын комисс хүлээн авсан байна.
- ✓ Тайлант онд ашиглалтад хүлээн авсан 54,850.5 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна**.**
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээний 82.5 хувийг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байна
- ✓ Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн нийт төсөл, арга хэмжээний 76.9 хувь нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

### АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

**УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 76.9 ХУВЬТАЙ БАЙНА.**

**Аудитын дүн:** Аудитаар нийт ***58,128.1* сая төгрөгийн** зөрчил илэрснээс 6.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 58,121.4 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 2 заалт бүхий зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

--------------------------o0o-------------------------------

# ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна .

**Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмидад**

1. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авахгүй байх

2. 2022-2023 онуудад хэрэгжүүлж дуусахаар гэрээ байгуулсан боловч гэрээт хугацаанд ашиглалтад оруулаагүй төсөл, арга хэмжээний шалтгааныг тодорхойлж, нэн яаралтай ашиглалтад оруулах арга хэмжээ авах

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлснээр шинээр ашиглалтад орох барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл сайжирч, чанарын шаардлага хангасан, төлөвлөсөн үр дүнд хүрэх хөрөнгө оруулалтын үр өгөөж бий болно.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 05 дугаарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2024 оны 11 дүгээр сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛБАР:

Шалгагдагч байгууллагаас тайлангийн төсөлтэй танилцаад саналгүй гэсэн хариу албан бичгийг ирүүлсэн.

**АРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3231,
Цахим шуудан: info@arkhangai.gov.mn,
Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2024. 04. 18 № 03/578

танай ______________-ны №______________-т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй холбоотой санал, тайлбаргүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ГОМБОДОРЖ

18/IV

652400900788

# ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ

АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 16 өдөр　　　Дугаар А/11　　　Эрдэнэбулган сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.3 Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18,9, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан "Эрх үүрэг шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.1, 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу "Улс,Орон нутгийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар батлсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймаг сумдын Засаг дарга болон ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР　　　Т.БАЙГАЛМАА

Тэргүүлэх аудиторын 2024 оны 04 сарын
16....өдрийн А/74 тоот тушаалын хавсралт №1

## "Улс төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитын код: АРА-2023/28-01-ШТА-ГА

| № | Хүргүүлсэн шийдвэрийн | | | | Хэрэгжилтийг хариуцах | |
|---|---|---|---|---|---|---|
| | Утга | Мөнгөн дүн | Тоо | Шийдвэр | Байгууллага, албан тушаал | Албан тушаалтны нэр |
| 1 | 1. БШУСайдаас аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн өмнөх оноос шилжих X.1.1.251 хуулийн дугаартай "Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Архангай, Ихтамир сум/" -ын ажлын гүйцэтгэгч "Тамир таун" ХХК нь 2022.04.15-нд 1,499.8 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ба барилгын ТЭЗҮ, зураг төсвөт гадна бохирын болон цэвэр усан хангамжийн систем суурилуулалт, халаалтын шугамын ажлын төсөв батлагдаагүйтэй холбоотойгоор барилгыг ашиглаж эхлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4 заалттай нийцэхгүй байна. | 1,499.80 | 1 | Албан шаардлага | Архангай аймгийн засаг дарга | Б.Цэрэннадмид |
| 2 | Аймгийн Засаг даргад Соёлын Сайдын багцаас 2022 онд эрх шилжүүлсэн "Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын ажил" /XI.1.54/ хуулийн дугаартай төсөл арга хэмжээний гүйцэтгэгч "Энигма констракшн" ХХК-тай 2022.05.01 нээс 2023.11.20-ныг хүртэл гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ч гэрээний хугацаанд ажил хийгдээгүй мөн 2022 онд батлагдсан нийт санхүүжилтээс 2022.06.30-нд урьдчилгаа төлбөрийн баталгаагаар 525,000.0 мянган төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ. . | 525.00 | 1 | Албан шаардлага | Архангай аймгийн засаг дарга | Б.Цэрэннадмид |
| 3 | Боловсрол шинжлэх ухааны Сайдаас 2022 онд эрх шилжсэн 1,978.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Багшийн хөгжил, судалгааны арга зүйн төвийн барилга"-ын ажлын гүйцэтгэгч "Эсгэл" ХХК нь улсын комиссоос өгсөн 2 үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй мөн ашиглалтын явцад дээвэр лүү гарах хаалга гажилт үүсч, цоож эвдэрсэн, 1, 3 давхрын 2 өрөөний дүүргэлтийн хана цууралт үүссэн зэрэг эвдрэлийг засварлах арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 14.6, 14.7 дахь хэсэг, МУЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.9.2-д "... барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагаар үнэ төлбөргүй, үл маргах журмаар засварлуулж, ашиглалтын хэвийн байдалд оруулах арга хэмжээ авна ..." гэсэн заалттай нийцэхгүй байна. | - | 1 | Албан шаардлага | Аймгийн ГХБХБГ-ын дарга | Ч.Отгонжаргал |
| 4 | 1. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хугацаа дуусгавар болсон хавсралтад дурдсан 5 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнээгүй, сунгалт хийгээгүй, хариуцлага тооцох арга хэмжээ аваагүй байгаа нь ТБОНӨХБАУХАТХ-ийн 46 дугаар 46.1.6 "Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавих...", МУЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилга захиалагчийн дүрэм"-ийн 3.6-д "Захиалагч ... гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, ... гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана", гүйцэтгэгч нартай байгуулсан гэрээний ерөнхий нөхцөлийн 46.1-д "Гүйцэтгэгч ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутам гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө" гэж заасантай нийцэхгүй байна. | - | 1 | Албан шаардлага | Аймгийн ГХБХБГ-ын дарга | Ч.Отгонжаргал |
| 5 | БОАЖСайдын багцаас эрх шилжээгүй 2023 онд орон нутагт хэрэгжсэн 1,096.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын барилга /Архангай, Өвөрхангай, Булган/"-ын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссоос өгсөн 9 үүрэг даалгаврыг, БШУСайдаас эрх шилжүүлсэн 1,978.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Багшийн хөгжил, судалгааны арга зүйн төвийн барилга"-ын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссоос өгсөн 2 үүрэг даалгаврыг мөн 1,499.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Архангай, Ихтамир сум/" -ын ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссоос өгсөн 5 үүрэг даалгаврыг гүйцэтгэгч талууд ажлын 14 хоногт гүйцэтгээгүй байхад уг барилга байгууламжуудыг ашиглалтад оруулах шаардлага хангасан гэж үзэн ашиглалтад хүлээн авсан нь МУЗГ-ын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 8.1, 8.2.1 дэх заалттай нийцэхгүй байна. | - | 1 | Зөвлөмж | Архангай аймгийн засаг дарга | Б.Цэрэннадмид |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан 68,218.2 сая төгрөгийн гэрээний үнэтэй 20 төсөл, арга хэмжээнээс 54,850.5 сая төгрөгийн гэрээний үнэтэй 14 төсөл арга хэмжээг ашиглагч байгууллага нь нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.1, 4.1.4, 4.4 дэх заалттай нийцэхгүй байна. | **54,850.50** | 1 | Албан шаардлага | Аймгийн ОНӨГ-ын дарга | Х.Ганхуяг |
| 7 | 1. Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын багцаас эрх шилжээгүй орон нутагт хэрэгжсэн 1,096.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын барилга /Архангай, Өвөрхангай, Булган/"-ын гүйцэтгэгч "Жам" ХХК нь байнгын ашиглалтад оруулах улсын комиссоос өгсөн 9 үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй байна. | **1,096.10** | 1 | Албан шаардлага | Аймгийн ГХБХБГ-ын дарга | Ч.Отгонжаргал |
| 8 | 1. ХХААХҮС-аас эрх шилжсэн, өмнөх оноос шилжих XIII.3.10 хуулийн дугаартай "Малын ногоон тэжээл тариалах төсөл"-ийн хүрээнд 1-р багцаар 345,550.0 мянган төгрөгийн Foton lovol үр тарианы комбайн худалдан авч 3 иргэнтэй түрээсийн гэрээ байгуулан 16,000.0 мянган төгрөгөөр түрээслэн, түрээсийн төлбөрөөс 3,309.0 мянган төгрөгийг жолоочийн ажлын хөлсөнд өгч, үлдсэн төлбөр болох 12,691.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх байсан боловч 6,691.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь "Түрээсийн гэрээний 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг зөрчин түрээсийн төлбөрийг төвлөрүүлж, мөнгө тушаасан баримтыг хүлээлгэн өгсний дараа гэрээгээр эзэмшүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна. | **6.69** | 1 | Төлбөрийн акт | Аймгийн ОНӨГ-ын дарга | Х.Ганхуяг |
| 9 | 2. ХХААХҮС-аас эрх шилжсэн, өмнөх оноос шилжих XIII.3.10 хуулийн дугаартай Малын үүлдэр угсааг сайжруулах төслийн хүрээнд 2-р багцаар 150,000.0 мянган төгрөгийн хосолмол ашиг шимтэй Монбелиард үүлдрийн 9 үнээ, 10 бяруу нийт 19 үхрийг худалдан авч 2023 онд 1 ААН-тэй 5 жилийн хугацаанд түрээсээр ашиглуулах гэрээ байгуулсан ба гэрээнд 10 тол тутмаас 1 тугалыг түрээсийн төлбөрт төлөхөөр гэрээ байгуулсан боловч түрээсийн төлбөр төлөх нарийвчилсан хуваарь гаргаагүй, төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж үр ашиг дээшлүүлэх арга хэмжээ аваагүй нь МУЗГ-ын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 1.3-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээсээр эзэмшүүлэх зорилго нь төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна. | **150.00** | 1 | Албан шаардлага | Аймгийн ОНӨГ-ын дарга | Х.Ганхуяг |
| 10 | 2023 онд хэрэгжиж дуусах гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаанд гүйцэтгээгүй 5 ТАХ байна. Гэрээний хугацаанд гүйцэтгүүлэх арга хэмжээ аваагүй байна. | - | 1 | Зөвлөмж | Архангай аймгийн засаг дарга | Б.Цэрэннадмид |
| | **Төлбөрийн актын дүн** | **6.69** | **1** | | | |
| | **Албан шаардлагын дүн** | **58,121.40** | **7** | | | |
| | **Зөвлөмжийн дүн** | **-** | **2** | | | |
| | **НИЙТ ДҮН** | **58,128.09** | **10** | | | |

## Тайлангийн хавсралт №1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжсэн ТАХ-ний жагсаалт

Тайлангийн хавсралт №1

### АРХАНГАЙ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

| № | Хуулийн код | Төсөл, арга хэмжээний нэр | Төсөл, арга хэмжээний төрөл /Барилга байгууламж, Их засвар, Тоног төхөөрөмж, ТЭЗҮ/ | Шинээр эхлэх, шилжих эсэх /Шинэ, Шилжих/ | Хүчин чадал /суудлын тоо, орны тоо г.м тоон дүнгээр тодорхойж бичих/ | Төсвийн тухай хуулиарх | | | | | Төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлын гэрээний мэдээлэл | | | | | | Ажлын нийт гүйцэтгэл /Эхэлснээс хойш 2023 оны эцэс хүртэл/ | | ТАХ-ны хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эхлэх | Дуусах | Төсөвт өртөг | Санхүүжих | ТЕЗ өөрчлөлт оруулсан | Гүйцэтгэгч байгууллагын нэр | Гэрээ байгуулсан огноо | Гэрээний үнийн дүн: Анхны | Гэрээний үнийн дүн: Сүүлийн | Гэрээний эхлэх огноо | Гэрээний дуусах огноо | Мөнгөн дүн | Хувь | Хэрэгжиж дууссан эсэх /тийм, үгүй, хугацаа болоогүй/ |
| 1 | IX.1.16 | Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр /Архангай, Эрдэнэмандал сум/ | Барилга байгууламж | шилжих | | 2020 | 2023 | 5,022.30 | 280.00 | | "Бурхант хясаат" ХХК | 2020.06.16 | **3,995.0** | **4,275.03** | 2020.06.16 | 2020.12.15 | 4,275.0 | 100 | тийм |
| 2 | IX.1.127 | Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/ | инженерийн шугам сүлжээ | шилжих | 37 орон сууцны барилгын гадна фасад болон дээврийн засвар, 7.8 км явган зам, 7км урттай, 207ш авто замын гэрэлтүүлэг | 2022 | 2024 | 26,964.80 | 6,387.60 | | Энигма констракшн ХХК | 2022.04.26 | 26,964.8 | | 2022.05.10 | 2023.11.30 | 6,658.8 | 24.69 | үгүй |
| 3 | X.1.1.33 | Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Цахир сум/ | Барилга байгууламж | шилжих | *320 суудалтай* | 2019 | 2023 | 5,375.70 | 1,422.00 | | *Лорд скай ХХК* | 2019.10.04 | 3,150.0 | 5,375.8 | 2019.10.04 | 2023.08.30 | 4,691.3 | 66.2 | үгүй |
| 4 | X.1.1.36 | Сургуулийн өргөтгөлийн барилга, урлаг, спорт заал, 320 суудал /Архангай, Чулуут сум/ | Барилга байгууламж | шилжих | | 2019 | 2023 | 3,692.80 | 493.90 | | Цагаан уран хийц ХХК | 2019.12.10 | 3,198.6 | 3,692.8 | 2019.12.11 | 2023.06.01 | 3,692.8 | 100.0 | тийм |
| 5 | X.1.1.78 | Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 50 ор /Архангай, Тариат сум/ | Барилга байгууламж | шилжих | 50 ортой | 2019 | 2023 | 642.70 | 160.70 | | Хорго групп ХХК | 2019 | 482.0 | 855.7 | 2019.08.12 | 2024.09.01 | 787.70 | 92.0 | үгүй |
| 6 | X.1.1.90 | Сургуулийн барилгын өргөтгөл /Архангай, Хашаат сум/ | Барилга байгууламж | шилжих | | 2020 | 2023 | 1,148.50 | 225.50 | | Тамирын цахиур ХХК | 2020.05.22 | 923.0 | 1,148.5 | 2020.05.22 | 2022.08.25 | 1,148.5 | 100.0 | тийм |
| 7 | X.1.1.92 | Сургуулийн барилгын өргөтгөл /Архангай, Эрдэнэбулган сум, 3 дугаар сургууль/ | Барилга байгууламж | шилжих | | 2020 | 2023 | 775.20 | 78.30 | | Гурван тамир ХХК | 2020.04.17 | 700.0 | 775.2 | 2020.04.17 | 2021.08.20 | 775.2 | 100.0 | тийм |
| 8 | X.1.1.97 | Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Хайрхан сум/ | Барилга байгууламж | шилжих | *320 суудалтай* | 2020 | 2023 | 3,723.80 | 872.30 | | Эртний цамхаг констракшн ХХК | 2020.05.10 | 2,851.5 | 3,723.8 | 2020.05.10 | 2023.08.30 | 3,351.4 | 89.9 | үгүй |
| 9 | X.1.1.132 | Сургуулийн барилгын өргөтгөл /Архангай, Өлзийт сум/ | Барилга байгууламж | шилжих | | 2020 | 2023 | 974.20 | 182.20 | | Ди ти эм строй ХХК | 2020.05.22 | 790.1 | 972.3 | 2020.05.22 | 2023.08.31 | 920.9 | 94.6 | үгүй |
| 10 | X.1.1.145 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Архангай, Цахир сум/ | Барилга байгууламж | шилжих | *50 ортой* | 2020 | 2023 | 532.80 | 64.40 | | Гурван тамир ХХК | 2020.04.17 | 470.0 | 532.8 | 2020.04.17 | 2021.08.20 | 532.8 | 100.0 | тийм |
| 11 | X.1.1.154 | Сургуулийн барилгын өргөтгөл /Архангай, Эрдэнэбулган сум, 1 дүгээр сургууль/ | Барилга байгууламж | шилжих | | 2020 | 2023 | 4,035.90 | 640.90 | | Гурван тамир ХХК | 2020.05.15 | 3,395.0 | 4,035.9 | 2020.05.15 | 2021.10.01 | 4,035.9 | 100.0 | тийм |
| 12 | X.1.1.190 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 150 ор /Архангай, Эрдэнэбулган сум, 2 дугаар цэцэрлэг/ | Барилга байгууламж | шилжих | *150 ортой* | 2021 | 2023 | 2,031.80 | 466.80 | | РСТ ХХК | 2021.07.12 | 1,560.2 | 2,027.0 | 2021.07.12 | 2023.08.25 | 1,925.7 | 95.0 | тийм |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | X.1.1.251 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Архангай, Ихтамир сум/ | Барилга байгууламж | шилжих | | 2022 | 2023 | 1,499.90 | 1,359.90 | | Тамир таун ХХК | 2021.04.20 | 1,499.9 | | 2022.05.01 | 2023.07.31 | 1,424.9 | 94.9 | тийм |
| 14 | X.1.1.262 | Багшийн хөгжил, судалгааны арга зүйн төвийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум/ | Барилга байгууламж | шилжих | | 2022 | 2023 | 1,978.00 | 1,178.00 | | Эсгэл ХХК | 2022.04.12 | 1,978.0 | | 2022.05.01 | 2023.08.30 | 1,978.0 | 100.0 | тийм |
| 15 | X.1.1.271 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 150 ор /Архангай, Жаргалант сум/ | Барилга байгууламж | шилжих | 150 ортой | 2022 | 2023 | 2,868.40 | 2,748.40 | | Газрын гагнаас ХХК | 2022.04.29 | 2,864.9 | - | 2022.06.01 | 2023.08.30 | 2,629.2 | 91.8 | үгүй |
| 16 | X.1.1.278 | Бага сургуулийн барилга, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 6 дугаар баг/ | Барилга байгууламж | шилжих | 160 суудалтой | 2022 | 2024 | 4,137.70 | 2,315.20 | | Ди ти эм строй ХХК | 2022.04.29 | 4,137.6 | | 2022.04.29 | 2023.11.13 | 2,553.2 | 61.7 | үгүй |
| 17 | X.1.1.282 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Хотонт сум/ | Барилга байгууламж | шилжих | 150 ортой | 2022 | 2023 | 2,875.30 | 2,275.30 | | Билгүүн Од констракшн ХХК | 2022.04.13 | 2,875.3 | | 2022.4.13 | 2024.05.31 | 2,072.5 | 72.0 | үгүй |
| 18 | X.1.1.325 | Сургуулийн барилга, спорт заал, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 4 дүгээр сургууль/ | Барилга байгууламж | шилжих | спорт заал, 160 суудалтой | 2022 | 2023 | 3,834.40 | 3,634.40 | | Эйч ар ви констракшн ХХК | 2022.04.29 | 3,834.4 | | 2022.05.30 | 2023.12.30 | 3,339.1 | 87.0 | тийм |
| 19 | X.1.1.326 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Батцэнгэл сум, 1 дүгээр баг/ | Барилга байгууламж | шилжих | 150 ортой | 2022 | 2023 | 2,878.30 | 1,878.30 | | Идэр живаа ХХК | 2022.04.11 | 2,878.3 | | 2022.05.01 | 2023.08.15 | 2,646.1 | 94.9 | тийм |
| 20 | Сайдын багцаас | Боловсролын салбарын тоног төхөөрөмж | Тоног төхөөрөмж | шинэ | | 2023 | 2023 | 500.00 | 500.00 | | "Саммет компьютер технологи" ХХК | 2023.05.05 | 498.2 | | 2023.05.05 | 2023.05.23 | 498.2 | 100.0 | тийм |
| 21 | XI.1.21 | Солийн Данзаны нэрэмжит музей, цэцэрлэгт хүрээлэн /Архангай, Хотонт сум/ | Барилга байгууламж | шилжих | | 2019 | 2023 | 1,141.00 | 141.00 | | Жонш ХХК | 2019.07.19 | 1,141.0 | 0.0 | 2019.07.19 | 2023.10.01 | 913.7 | 80.0 | үгүй |
| 22 | XI.1.31 | Соёлын төвийн барилга, 250 суудал /Архангай, Чулуут сум/ | Барилга байгууламж | шилжих | 250 суудалтай | 2020 | 2023 | 1,738.70 | 260.40 | | "Эсгэл" ХХК | 2020.05.01 | 1,478.3 | 1,738.7 | 2020.05.01 | 2022.07.01 | 1,738.7 | 100.0 | Тийм |
| 23 | XI.1.39 | Соёлын төвийн барилга, 250 суудал /Архангай, Булган сум/ | Барилга байгууламж | шилжих | 250 суудалтай | 2020 | 2023 | 1,598.00 | 265.50 | | "Газрын гагнаас" ХХК | 2022.05.10 | 1,332.5 | 1,598.0 | 2020.05.10 | 2022.04.20 | 1,598.0 | 100.0 | Тийм |
| 24 | XI.1.40 | Соёлын төвийн барилга, 240 суудал /Архангай, Жаргалант сум/ | Барилга байгууламж | шилжих | 240 суудалтай | 2020 | 2023 | 1,785.40 | 277.70 | | "Газрын гагнаас" ХХК | 2022.05.10 | 1,150.0 | 1,785.4 | 2020.05.10 | 2023.05.01 | 1,785.4 | 100.0 | Тийм |
| 25 | XI.1.54 | Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/ | Барилга байгууламж | шилжих | | 2022 | 2024 | 4,075.30 | 1,489.10 | | Энигма констракшн ХХК | 2022.05.01 | 4,075.3 | | 2022.05.01 | 2023.11.20 | 0.0 | 0.0 | үгүй |
| 26 | XI.2.2 | Соёлын төв, спорт заалны их засвар /Архангай, Хангай сум/ | Барилга байгууламж | шилжих | | 2020 | 2023 | 347.50 | 48.10 | | "Цагаан сүмбэр" ХХК | 2020.06.16 | 299.4 | 346.4 | 2020.06.16 | 2021.07.01 | 341.9 | 100.0 | Тийм |

| | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | XII.1.1.8 | Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км /Архангай, Батцэнгэл сум/ | зам, гүүр | шилжих | 63 км | 2019 | 2024 | 71,070.5 | 19,572.4 | | Хурдны зам ХХК | 2019.12.20 | 62,493.8 | 71,070.5 | 2019.12.20 | 2024.11.25 | 50,542.4 | 71.1 | үгүй |
| 28 | XII.1.1.62 | Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Өгийнуур-Батцэнгэл-Ихтамир чиглэлийн А27 дугаартай мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх авто замын ажлын 2 дугаар хэсэг, 7 км /Архангай/ | зам, гүүр | шилжих | 7 км | 2022 | 2023 | 6,215.50 | 4,715.50 | | Саруул харгүй ХХК | 2022.04.07 | | 6,215.5 | 2022.04.07 | 2023.10.30 | 6,122.8 | 99.0 | тийм |
| 29 | XII.1.1.67 | Өндөр-Улаан багийн Донгой багаас Чулуут сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 65.8 км /Архангай, Ихтамир, Чулуут сум/ | зам, гүүр | шилжих | 65.8 км | 2022 | 2024 | 39,452.70 | 15,170.60 | | ЗЗБ ХХК | 2022.07.29 | 39,452.7 | | 2022.07.29 | 2024.12.15 | 13,317.6 | 33.8 | үгүй |
| 30 | XII.1.1.74 | Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Архангай, Тариат сум/ | зам, гүүр | шилжих | 1.8 км | 2022 | 2023 | 2,353.20 | 2,193.20 | | Авто зам ХХК | 2022.04.27 | 2,353.2 | | 2022.04.27 | 2023.11.20 | 2,353.2 | 100.0 | тийм |
| 31 | XII.1.1.76 | Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Архангай, Хангай сум/ | зам, гүүр | шилжих | 2.2 км | 2022 | 2023 | 2,496.10 | 2,336.10 | | Эвт-Уул ХХК | 2022.04.27 | 2,496.1 | | 2022.04.27 | 2023.11.05 | 2,496.1 | 100.0 | тийм |
| 32 | XII.2.1.4 | Хануйн голын төмөр бетон гүүр /Архангай, Эрдэнэмандал сум/ | зам, гүүр | шилжих | | 2020 | 2023 | 3,677.00 | 178.60 | | Эвт-Уул ХХК | 2020.05.19 | 3,500.0 | 3,677.0 | 2020.05.19 | 2023.07.01 | 3,677.0 | 100.0 | тийм |
| 33 | XIII.3.4 | Малын ногоон тэжээл тариалах төсөл, тоног төхөөрөмж /Архангай/ | Тоног төхөөрөмж | шилжих | | 2022 | 2023 | 400.00 | 320.00 | | "Скайблю фортун" ХХК | 2022.12.16 | 345.6 | 345.6 | 2022.12.19 | 2023.04.01 | 345.6 | 100.0 | тийм |
| 34 | XIII.3.10 | Малын үүлдэр, угсаа сайжруулах төсөл /Архангай/ | Тоног төхөөрөмж | шилжих | | 2022 | 2023 | 351.00 | 271.00 | | "Синапс" ХХК | 2022.05.04 | 51.8 | | 2022.05.04 | 2023.02.01 | 51.8 | 100.0 | тийм |
| 35 | | | | | | | | | | | "Энх сүү наф" ХХК | 2022.08.11 | 150.0 | | 2022.08.11 | 2023.10.11 | 150.0 | 100.0 | тийм |

| | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | | | | | | | | | | | "Бар үр хатан" ХХК | 2022.05.04 | **148.8** | | 2022.05.04 | 2023.09.01 | 148.8 | 100.0 | тийм |
| 37 | XIV.1.41 | Сумын төвөөс Бор бургастын рашаан хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын ажил, зураг төсөв /Архангай, Төвшрүүлэх сум/ | Барилга байгууламж | шилжих | 100 Ква | 2022 | 2023 | 998.6 | 548.6 | | Кон-Арч ХХК | 2023.05.30 | **525.1** | | 2023.06.02 | 2023.08.15 | 525.1 | 100.0 | тийм |
| 38 | XV.3.6 | Хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн явуулын авто машин /Архангай/ | Тоног төхөөрөмж | шилжих | | 2022 | 2023 | 350.00 | 280.00 | | "Ач өсөн энх" ХХК | 2022.05.16 | **344.8** | **0.0** | 2022.05.20 | 2023.05.16 | 344.8 | 100.0 | тийм |
| | **НИЙТ ДҮН** | | | | | | | **213,543.0** | **75,231.9** | **-** | **-** | | **190,385.2** | **114,191.8** | **-** | **-** | **136,390.3** | **88.1** | **-** |

Судалгаа гаргасан: Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ

Хянасан: Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Баталгаажуулсан: Дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Тамга тэмдэг

огноо:

## Тайлангийн хавсралт №2. Ашиглалтад хүлээн авсан ТАХ-г Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байдлын судалгаа

*Тайлангийн хавсралт №2*

**Улс орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын нягтлан бодох бүртгэлд тусгагдаагүй хөрөнгийн дэлгэрэнгүй судалгаа**

2024.04.18

| № | Сайд | Төсөл арга хэмжээний нэр | Хуулийн дугаар | Эрх шилжсэн эсэх | Гүйцэтгэгчийн нэр | Гэрээний дүн | Улсын комиссын актын: огноо | Улсын комиссын актын: дугаар | Хөрөнгийн бүртгэлд тусгасан байдал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ХХАА | Малын үүлдэр угсаа сайжруулах төсөл | XIII.3.10 | Тийм | "Энх сүү наф" ХХК | 110.50 | 2023.07.20 | 1 | Бүртгэлд тусгаагүй |
| 2 | Боловсрол | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Архангай, Ихтамир сум/ | X.1.1.251 | Тийм | "Тамир таун" ХХК | 1,499.90 | 2023.10.18 | ББОАКД-2023/46 | Бүртгэлд тусгаагүй |
| 3 | Боловсрол | Сургуулийн барилга, спорт заал, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 4 дүгээр сургууль/ | X.1.1.325 | Тийм | Эйч ар ви констракшн ХХК | 3,834.37 | | | Бүртгэлд тусгаагүй |
| 4 | ЗТХС | Хархорин-Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Өгийнуур-Батцэнгэл-Ихтамир чиглэлийн А27 дугаартай мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх авто замын ажлын 2 дугаар хэсэг, 7 км /Архангай/ | XII.1.1.62 | Тийм | Саруул харгуй ХХК | 6,215.50 | 2023.12.05 | №2023/11 | Бүртгэлд тусгаагүй |
| 5 | ЗТХС | Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Архангай, Тариат сум/ | XII.1.1.74 | Тийм | Авто зам ХХК | 2,353.21 | 2023.10.06 | №2023 | Бүртгэлд тусгаагүй |
| 6 | ЗТХС | Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Архангай, Өндөр-Улаан сум/ | XII.1.1.50 | Үгүй | "Саруул харгуй" ХХК | 5,795.60 | | | Бүртгэлд тусгаагүй |
| 7 | ЗТХС | Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Архангай, Хангай сум/ | XII.1.1.76 | Тийм | Эвт-Уул ХХК | 2,496.10 | 2023.11.20 | ЗТХЯ/2023 | Бүртгэлд тусгаагүй |
| 8 | Соёл урлаг | Соёлын төвийн барилга, 250 суудал /Архангай, Булган сум/ | XI.1.39 | Тийм | "Газрын гагнаас" ХХК | 1,597.99 | 2023.05.20 | ББАОКД-2023/ | Бүртгэлд тусгаагүй |
| 9 | Соёл урлаг | Соёлын төвийн барилга, 240 суудал /Архангай, Жаргалант сум/ | XI.1.40 | Тийм | "Газрын гагнаас" ХХК | 1,785.40 | 2023.09.18 | ББАОКД-2023/39 | Бүртгэлд тусгаагүй |
| 10 | Соёл урлаг | Соёлын төвийн барилга, 240 суудал /Архангай, Чулуут сум/ | XI.1.40 | Тийм | "Газрын гагнаас" ХХК | 260.41 | - | - | Материалын үнийн зөрүү бүртгэлд тусгаагүй |
| 11 | БОАЖ | Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулах | - | Үгүй | "Жам" ХХК | 1,096.00 | - | - | Бүртгэлд тусгаагүй |
| 12 | ЭМС | Эрүүл мэндийн төвийн барилга 10 ор /Архангай, Цахир сум/ | XV.1.6 | Үгүй | "Ган-Зосон" ХХК | 2,067.00 | - | - | Бүртгэлд тусгаагүй |
| 13 | ЭМС | Нэгдсэн эмнэлгийн барилга, 300 ор /Архангай, Эрдэнэбулган сум/ | XV.1.20 | Үгүй | "Гурвантамир" ХХК | 25,213.40 | - | - | Бүртгэлд тусгаагүй |
| 14 | ЭХС | Сумын төвөөс Бор бургастын рашаан хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын ажил, зураг төсөв /Архангай, Төвшрүүлэх сум/ | XIV.1.41 | Тийм | Кон-Арч ХХК | 525.1 | 2023.09.18 | ББАОКД-2023/28 | Бүртгэлд тусгаагүй |
| **Нийт дүн** | | | | | | **54,850.53** | | | |

Судалгаа гаргасан: Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ

Хянасан: Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Баталгаажуулсан: Дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Тамга тэмдэг